ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр Дугаар А/28 Аргатай

Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн жагсаалтын хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг хэлэлцэн зөвлөмж дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 6.1, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн жагсаалтын хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг хэлэлцэн зөвлөмж дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга Р.Отгонбаатар (ЗДТГ-ын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхзул (Төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Т.Дуламханд (Санхүү албаны дарга)

Т.Шуухааз (Байгаль орчны мэргэжилтэн)

Ц.Батбилэг (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

М.Мөнгөнхуяг (1,3 дугаар багийн Засаг дарга)

Э.Дашдамба (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Цэцэгжаргал (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

С.Цэрэн-Янжин (ЕБС-ийн захирал)

Б.Батчимэг (Соёлын төвийн дарга)

М.Цэенсүрэн (ЭМТ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгч)

2. Орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтыг ард иргэдийн саналтай уялдуулан дүн шинжилгээ хийж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга, ажлын хэсгийн ахлагч (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/02 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЗОЛЗАЯА 482301070

This PC/Local disk(D)/2023он/эз-н актууд/захирамж 2023